



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 12 сарын 30 өдөр

Дугаар А/817

Арвайхээр

Газар зүйн нэрийн салбар зөвлөл
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Геодези, зураг зүйн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.8.2, 5.8.4, 11 дүгээр зүйлийн 11.1, 11.2 дахь заалт, Улсын Их Хурлын “Газар зүйн нэрийн жагсаалт батлах тухай” 2003 оны 42 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхийлөгчийн “Нутаг орны газар зүйн нэрийг хамгаалах тухай” 2017 оны 186 дугаар зарлигийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн “Газар зүйн нэрийн салбар зөвлөл”-ийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

- Салбар зөвлөлийн дарга: -Засаг даргын орлогч
Нарийн бичгийн дарга: -Аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга
- Гишүүд: -Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Нарийн бичгийн дарга
-Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга
-Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
-Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга
-Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга
-Засаг даргын Тамгын газрын Архивын тасгийн дарга
Аймгийн Засаг даргын дэргэдэх Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга
Аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол, соёл, урлагийн газрын Соёлын хэлтсийн дарга
Аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга
Онги-Таац голын сав газрын захиргааны дарга
Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн захирагч (зөвшилцсөнөөр)
Өвөрхангай Автотээврийн төвийн дарга
“Мэдээлэл Холбооны Сүлжээ” ХХК-ийн Өвөрхангай аймгийн газрын дарга
“Монголын цахилгаан холбоо” ХК-ийн Өвөрхангай аймгийн Холбооны газрын дарга
Аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Геодези, зураг зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн

011101563

2. Аймагт “Газар зүйн нэрийн салбар зөвлөл” байгуулсантай холбогдуулан 19 суманд салбар зөвлөл байгуулах тухай заавар, зөвлөмжийг хүргүүлэх, ажиллах дүрмийн хүрээнд Нэрийн салбар зөвлөлийн хурлыг зохион байгуулж ажиллахыг Газар зүйн салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга (Ч.Гүнсэнхорол)-т даалгасугай.

3. “Газар зүйн нэрийн хээрийн тодруулалтыг аймгийн хэмжээнд хийх” ажлыг зохион байгуулах, “Газар зүйн нэрийн мэдээллийн сан” бүрдүүлэх, шинээр өгөх болон өөрчлөх газар зүйн нэрийг хэлэлцэн Газар зүйн нэрийн зөвлөлд хүргүүлэх болон бусад ажлуудыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг тухай бүрд шийдвэрлэн ажиллахыг (Санхүү, төрийн сангийн хэлтэс), (Газар зүйн нэрийн салбар зөвлөлийн дарга) нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД